

**Монгол хэлний үзэмчин аялгууны
өнөөгийн нөхцөл байдлын судалгаа**

Дашидондогийн БОРОЛЗОЙ*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Хэл шинжлэлийн салбар

Received: 13 October 2025 / **Accepted:** 20 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбараас 2022-2024 онд “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” суурь судалгааны төсөл амжилттай хэрэгжүүлсэн билээ. Төслийн хүрээнд 9 судлаач Монгол улсын 12 аймгийн 40-өөд сумын нутгаар хээрийн шинжилгээний ангиар явж, монгол хэлний нутгийн аялгуу, салбар аман аялгуунуудын хэрэглэгдэхүүн цуглуулж, өөр хооронд нь харьцуулан авиа зүй, хэл зүй, үгийн сангийн түвшинд харьцангуй цогцоор судалсан юм. Миний бие тус төсөлд үзэмчин аялгууны судалгааг хариуцан ажилласан болно. Төслийн үр дүнд хэвлүүлсэн номын онцлог нь аялгуу, аман аялгуу, салбар аман аялгууны хэрэглэгдэхүүнийг авиа зүй, хэл зүй, үгийн сангийн түвшинд өөр хооронд нь харьцуулан сүлжиж бичсэнд оршино. Харин тус өгүүлэлд үзэмчин аялгууны судалгааг нэг дор дангаар нь цэгцтэйгээр танилцуулав. Өнөөдөр монгол хэлний нутгийн аялгуунууд халх аялгуундаа жигдрэн уусаж байна гэж энгийн ажиглалтаар хэлж болохоор байна. Уг өгүүлэлд 2024 оны 5-р сард Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн, Сэргэлэн болон Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумдын нутгаар явж үзэмчин угсаатан хүмүүс хэл аялгуу, ёс заншлаа хэрхэн, ямар хэмжээнд хадгалж буй өнөөгийн бодит байдал болон статистик судалгааны дүнгийн талаар өгүүлнэ.

Түлхүүр үгс: Монгол хэлний үзэмчин аялгуу, нутгийн аялгууны өнөөгийн онцлог, статистик судалгаа

**The Current Status
of the Üzümchin Subdialect of Mongolian Language**

BOROLZOI Dashdondog

Department of Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The research project entitled “Research on Local Dialects of the Mongolian Language” was conducted at the Department of Linguistics, Institute of Linguistics, Mongolian

* © Д. Боролзой, 2025, Email: borolzoid@mas.ac.mm



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Academy of Sciences, between 2022 and 2024. The project aimed to document and analyze regional varieties of the Mongolian language through fieldwork carried out in 40 soums across 12 aimags by a team of nine researchers. Unlike previous studies that primarily focused on the phonological or lexical features of individual dialects, this study employed a comparative and multidimensional approach, examining phonological, grammatical, and lexical levels across multiple dialects and sub-dialects.

The research findings indicate a marked tendency toward dialectal convergence, with local varieties increasingly merging into the Khalkh dialect, the contemporary standard of Mongolian. A statistical survey conducted in May 2024 in Kherlen, Bayantumen, and Sergelen soums of Dornod aimag, and Erdenetsagaan soum of Sukhbaatar aimag, focused on the Üzümchin ethnic group, whose traditional dialect is undergoing significant change. While the Üzümchin people are actively reviving their cultural and historical identity, linguistic data reveal that the Üzümchin dialect is rapidly declining, with its distinctive features being absorbed into the Khalkh dialect. Overall, the study highlights the ongoing process of linguistic homogenization within Mongolia and underscores the urgency of documenting endangered dialectal varieties as part of national linguistic heritage.

Key words: *Üzümchin Dialect of Mongolian Language, Current Characteristics, Statistical Research*

1. Удиртгал

Үзэмчин бол Монголын эртний угсаатнуудын нэг мөн. Үзэмчний аман түүх, овгийн бүрэлдэхүүн, ёс заншил, аж ахуй зэрэгт нь үндэслэн, тэднийг XIII зууны үед ойн иргэдийн бүрэлдэхүүнд багтаж Их монгол улсын захиргаанд орсон хэмээн түүхчид үздэг ажээ.

Домог, хуучид өгүүлснээр үзэмчнүүд нь Алтай, Хангайн завсарт “Үзмийн цагаан уул” хэмээх газарт нутаглаж байсан бөгөөд үймээн самууны их хөлөөс дайжин өнөөгийн нутагтаа ирж суурьшсан ч унаган нутаг усаа санагалзан эмээлийн бүүргээ баруун хойш харуулж тавьдаг болжээ. “Амтлаг сайхан жимс ургадаг Үзэм хайрхан уул Даянтангийн даваанаас урагш Төөтгөнө хэмээх алтны уурхайтай газар бий гэнэ. Түүний баруун өмнө орших ганц шовх уулыг Үзэм уул хэмээн нэрлэдэг байжээ. Тус нутагт амьдарч аж төрж байсан хэсэг монголчууд Үзэмийн ууланд ургасан зэрлэг үзмийг түүж, хүнс тэжээлийн хэрэгцээнд хэрэглэхийн зэрэгцээ худалдан борлуулах ажил эрхэлсэн учир үзэмчин хэмээх нэртэй болжээ” (Наранцэцэг, 2011: 23).

Эдүгээ Монгол улсын Дорнод аймгийн Сэргэлэн суманд 300 гаруй өрх, Баянтүмэн суманд 100 гаруй өрх, Булган суманд 40-өөд өрх, аймгийн төв буюу Хэрлэн суманд 100 гаруй өрх үзэмчин угсаатан хүмүүс амьдарч байна. Үзэмчин аялгууг судлах ажлын хүрээнд “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” төслийн гишүүн миний бие 2024 оны 5-р сард Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн, Сэргэлэн сумд болон Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд ажилласан бөгөөд олон төрлийн ажил эрхлэн аж төрж буй нас насны үзэмчин хүмүүсийн төлөөлөлтэй уулзаж эдгээр нутаг дахь үзэмчин аялгууны хэрэглээний өнөөгийн байдал, соёл, ёс заншлын талаар баримт материал цуглуулан, статистик судалгаа хийсэн юм.

Өнгөрсөн зууны ерэн оноос хойш монголчуудын үндэсний үзэл үнэхээр сэргэн мандсантай маргах хүн гарахгүй биз ээ. Сүүлийн үеийн залуучууд монголоо алдах биш харин ч олох гээд дээлээ ч өмсөөд, хөөргөө ч бариад, ёс заншлаа ч дагаад үндэсний юм бүхэн сэргэж, өргөжин дэлгэрч байна. Үүний нэгэн адил үзэмчин угсаатны ёс заншил нэлээд сэргэж байгаа хандлага Дорнод аймгийн үзэмчнүүдийн ахуй амьдрал, хандлагаас харагдаж байв. Тухайлбал, тэд эзэн Чингисийнхээ хүлэг морины дөрөөг сүлд шүтээнээ болгон тахиж ирсэн түүхэн уламжлалтай бөгөөд үзэмчин ардын соёл, урлаг, спортын “Алтан дөрөө” наадмыг 3 жил тутамд тогтмол зохион байгуулдаг уламжлал тогтжээ. Мөн үзэмчин түмний алдарт “Жилийн цай уух ёслол”-ыг жил бүр Улаанбаатар хотод зохион байгуулж үүндээ үзэмчин ард иргэд маань идэвхтэй оролцдог болжээ.

2. Судалгааны арга зүй

Бид баримт цуглуулах, статистик тооцоолол, задлан шинжлэх, тайлбарлах зэрэг судалгааны арга хэрэглэв. Үзэмчин угсаатан хүмүүстэй уулзах үед бичиж тэмдэглэж авсан тэмдэглэл, аудио, видео бичлэг болон 4 насны үечлэлээр 170 орчим үзэмчин угсаатнаас авсан статистик судалгааны үр дүн гол хэрэглэгдэхүүн болов.

3. Үзэмчин аялгууг судалсан байдал

“Үзэмчин судлалын үндсэн хэрэглэгдэхүүн XVII-XVIII зууны үеэс эхэлдэг. Төвөд сургуулийн захиран сургагч санд, дөрвөн хэлэнд (монгол, төвөд, манж, хятад) хэтэрхийээ мэргэшсэн үзэмчин гүн Гомбожав 1735 онд “Гангын урсгал” гэдэг түүхэн зохиолдоо үзэмчний ноёдын угсаа гарал, үзэмчин хошууны зохион байгуулалт зэргийг дурдан бичсэн байдаг” (Төмөрцэрэн, [1974] 2023: 21) байна. Гэвч XX зууны дунд үе хүртэл үзэмчнийг тусгайлан судалсан зохиол гараагүй юм.

Үзэмчнүүдийн угсаа гарвал, түүхэн замнал, хэл аялгууны талаар ӨМӨЗО-д аж төрөн сууж буй үзэмчнүүдээр төлөөлөн судалсан эрдэм шинжилгээний хэд хэдэн бүтээл, өгүүлэл бий. Тухайлбал, Ж.Карагийн “Un glossaire üjümčün” (Үзэмчин толь бичиг. 1963), Боошиан, Чимэг нарын “Үзэмчин аман аялгуу” (1995), Хөхбарс, Чимэг нарын “Үзэмчин аман аялгуу” (1997), Н.Түвдэн нарын “Чин улсын үеийн Үзэмчин зүүнгарын хошуу” (1999), Д.Наранцэцэг, Д.Долгорсүрэн нарын “Үзэмчиний түүх соёлын ойллого” (2011) хэмээх нэг сэдэвт бүтээлүүд, Хонгорговийн “Үзэмчин өвөрмөц хэллэг” (2022) эмхэтгэл хэвлэгдэж, Боржигин Ламжавын, Чимэгийн “Үзэмчин аман аялгууны өвөрмөц үгсийн онцлог” (‘Монгол хэл, утга зохиол’ 1988, №6/100/), Номинтуяагийн “Үзэмчин аман аялгууны эгшиг авиалбар” (‘Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн сэтгүүл’, 1992) зэрэг өгүүлэл нийтлэгджээ.

Харин Монгол улсад суугаа үзэмчнүүдийн талаар Ж.Төмөрцэрэн анхны өгүүлэл, нэг сэдэвт зохиолыг бичсэн байна. Тэрээр “Үзэмчин аялгууны зарим онцлогоос”¹, “Үзэмчин аялгууг судалсан тэмдэглэлээс”² хэмээх хоёр өгүүлэл нийтлүүлж, 1974 онд “Үзэмчин аман аялгууны харшуулсан түүхэн судлал” хэмээх нэг сэдэвт зохиол бичжээ. “Энэ зохиолын гол хэрэглэгдэхүүн нь Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн, Булган сумын үзэмчин аман аялгуу болно. Мөн Чойбалсан, Улаанбаатар хотод бүхий үзэмчний өвгөд хөгшидтэй уулзаж, зарим ээдрээтэй асуудлыг шүүн магадаллаа” гэж өөрөө дурдсан байдаг. Өнөө үед Монгол Улсад суугаа үзэмчнүүдийн хэл яриа халх аялгуунд нэгэнт уусаж, ялгарахаа бараг больсон тул 1960-1970-аад оны түүхэн баримтыг бичиж үлдээсэн түүний энэхүү бүтээлүүд хэл шинжлэлийн хувьд асар үнэ цэнтэй билээ. Гэвч тэрээр тус зохиолоо хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилж бичсэн боловч цаг үеийн нөхцөл байдлаас болж горилсон зэргээ хамгаалж чадаагүй юм.

Тус зохиолд тухайн үеийн үзэмчин аялгууны онцлогийг бичсэн байдлыг товч дурдвал:

Авиа зүйн хувьд: “Үзэмчин аялгууны эгшиг авиаг хэлэхэд өгүүлэхүй эрхтний булчин хэр зэрэг чангарч байгааг харгалзан эр буюу чанга, эм буюу хөндий гэж ялгаж үзнэ.

Эр эгшиг нь: а (~а), і, о (~о), у (~у), а, օ, ү, і, а̄ (ā), օ̄ (ō), ү̄ (ū), а, օ, у

Эм эгшиг нь: е, і, օ (~о), ү (~ү), е, і, օ, ү, ē (~ē), օ̄ (~ō), ү̄ (~ū), е” (Төмөрцэрэн, [1974] 2023: 27) юм³. Мөн “үзэмчин аялгууны эгшиг авиаг хэлэхэд урт удаан буюу огцом түргэн шинжийг харгалзан урт эгшиг, богино эгшиг гэж ялган үзнэ.

Урт: а, е, і, і, օ, օ, а̄, օ̄, ү̄, е.

Богино: а (~а), е, і, і, о (~о), у (~у), օ (~о), ү (~ү), а, օ, у, е” (Төмөрцэрэн, [1974] 2023: 28) байна.

¹ Ж.Төмөрцэрэн. Үзэмчин аялгууны зарим онцлогоос. –“Acta Mongolica”, УБ., 1964, №4; ‘Монгол судлалын зарим асуудал’ УБ., 1964, Т.IV, F.1

² Ж.Төмөрцэрэн. Үзэмчин аялгууг судалсан тэмдэглэлээс. –“Монголын судлал”, УБ., 1969 (1968), Т.VI, F.33

³ Зохиогчийн өөрийн нь хэрэглэсэн галигаар

Мөн үзэмчин аялгууны гийгүүлэгч авиаг хэлэхэд дуу, анир хэрхэн оролцож байгаа хийгээд өгүүлэхүй эрхтний булчингийн чангарах хэмжээг үндэс болгон чанга, сул, сонсголонт гэж гурван хэсэг болгон ангилжээ. Энэ нь “Чанга: t, t̃, s, š, x, x, (p), (f), (^kx); Сул: d, d̃, g, g, b, (w), (L); Сонсголонт: m, n, ŋ, l, r, y” (Төмөрцэрэн, [1974] 2023: 29) байна.

Үзэмчин аялгууны авиалбарын бүрэлдэхүүн нь ерөнхийдөө халх аялгуунаас ялгагдах нь бага ч анхаарах хэдэн зүйл байдаг. Үзэмчин аялгуунд а, о, у эгшиг нь ä, ö, u эгшигтэйгээ урдуур, хойгуурын шинжээрээ /буюу эс тагнайшсан, тагнайшсан шинжээрээ/ эсрэгцэн утга ялгадаг байна. Жишээлбэл: am (ам) : äm (амь), bar (бар) : bär (барь), bod (бод) : bōd (бодь), ur (ур) : ūr (урь) гэх мэт. Үзэмчин аялгуунд эр j, эм i хоёрыг тодорхой ялгаж хэлэх бөгөөд тус тусдаа бие даасан авиалбарын үүрэг гүйцэтгэнэ. xir (хяр) : xir (хир), d̃jis (жяс) : d̃jis (зэс). Хэлний уруудах эм эгшиг è нь уужим, уйтны шинжээрээ е эгшигтэй эсрэгцэн утга ялгана. èxè (эх адаг) : exè (эцэг эхийн), bexè (бийр бэхийн) : bèxè (бат бэхийн). Мөн ò, ô хоёр уужим, уйтан шинжээрээ эсрэгцэн утга ялгана. xōs (хөөс) : xōs (хүйс) гэх мэт.

Мөн үзэмчин аялгуунд монгол бичгийн хэлний “ügiyiremüi гэхийг ügürēne~ügiṛēne, namjiṽsan гэхийг namd̃sāṇ~namdsāṇ, umsiṽu гэхийг uṇšīṽa~umšīṽa гэх зэргээр хэлж байдгаас гадна үгийн 1-р үеэс хойш орсон богино эгшигийн зүйлийг чөлөөтэй сэлгэн хэлэх нь үлэмж байх учир монгол бичгийн хэлний toṽsin гэхийг došgōṇ~došgīṇ, qudduṽ гэхийг xudāg~xudūg” (Төмөрцэрэн, [1974] 2023: 31) гэж дууддаг байна.

Үзэмчин аялгууг судлах нь монгол хэлний түүхийн нэгээхэн хэсгийг судлах болон монгол хэлийг бусад төрөл хэлтэй харьцуулан судлахад маш чухал ач холбогдолтой. Тухайлбал, өмнөх үеийн судалгаанаас зарим нэг хэлний онцлогийг дурдвал: Баруун үзэмчний аман аялгуунд ажигласан авиа зүйн ажиглалт гэвэл шүхэр, шатар, шохой, шүтээн зэрэг үгсийг jüxer, jitar, jütēṇ гэж хэлдгийг эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Гэвч ямар авианы нөлөөгөөр хэрхэн ингэж хэлдгийг тодруулсангүй байна. Баримтыг ажиглаж үзвэл өнөөгийн үзэмчинд шавар, шорой, шугам гэх мэт өдий төдий үгийн ш авиаг хэвээр нь хэлдэг байтал шүхрийг jüxer, шатрыг jītār гэж хэлж буй нь 2-р үеийн чанга гийгүүлэгчийн нөлөө нэг талаас, нөгөө талаас эртний монгол хэлний i авианы тагнайшуулах нөлөөлөл хоёроос шалтгаалж хэлний дундуур хэлэгдэх j гийгүүлэгчтэй сэлгэх боломжтой болсноос š~j авиа сэлгэжээ (Төмөрцэрэн, [1974] 2023: 68) гэж дүгнэсэн байдаг.

Хэл зүйн хувьд: харьяалахын тийн ялгалын нөхцөл -ā (-ē, -ō, -ō), -ṇ (-n), -ṇṇ (-ṇṇ) хэлбэртэй (adūnā, temēnē, aṽṇ, geṽṇ), заахын тийн ялгалын нөхцөл -īg~ī (-īg~ī), -c(-c), -g(-g) хэлбэртэй (gaṽāc, aṽī), өгөх орших тийн ялгалын нөхцөл эгшиг нь сугарсан, сугараагүй -d (-da, -de, -dō, -dō), -t (-ta, -te, -tō, -tō) хувилбартай (aṽād, galda, t̃sirīcte), холбох тийн ялгалын -lā (-lē, -lō, -lō) нөхцөлтэй (aṽlā, modlō), зүг чигийн тийн ялгал -d̃zū (-d̃zū) нөхцөлтэй (gard̃zū, gerd̃zū), үйл үгийн өнгөрсөн цаг заах нөхцөл -d̃zāc (-d̃zēc, -d̃zōc, -d̃zōc), -t̃šā (-t̃šē, -t̃šō, -t̃šō) хэлбэртэй (yawd̃zā, gart̃šā), нөхцөл үйлийн дутагдах нөхцөл -yāt̃si (-yēt̃si, -yōt̃si, -yōt̃si), -wt̃si (-wt̃si) хэлбэртэй (iryēt̃si-ирэвч), угтах нөхцөл -tār (-tēr, -tōr, -tor) хэлбэртэй (oṽtōr-ортол), дагалдах нөхцөл -xlā (-xlē, -xlō, -xlō) хэлбэртэй (irēxlē-ирэхлээр) гэх мэтээр халхаас өөр байжээ. Мөн үйлт нэрийн нөхцөлүүд -xa (-xē, -xō, -xō) /yawāx~yawxā/, -gt̃si (-gt̃si) /erxlēgt̃si/ болон нөхцөл үйлийн нөхцөлүүд -d̃zī (d̃zī), -t̃šī (-t̃šī) /ird̃zī/ гэх мэтээр балархай эгшиг нь сугараагүй байсан байна. Мөн -bā? гэдэг асуух сул үг өргөн хэрэглэдэг байжээ. (Төмөрцэрэн, [1974] 2023: 82-103).

Харин үгийн сангийн талаар Ж.Төмөрцэрэн уг бүтээлдээ дурдаагүй байна.

4. Үзэмчин аялгуу, ёс заншлын өнөөгийн байдал

Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэн, Үзэмчин судлалыг дэмжих нийгэмлэгийн тэргүүн Л.Түвдэнням “Үнэнийг хэлэхэд буриадыг бодвол барга, үзэмчнүүд нэлээд халхажсан. Жинхэнэ сайхан үзэмчин аялгаар ярьдаг хөгшчүүд байхгүй болж байна. 2005 онд анх “Алтан дөрөө” наадмыг хийж байхад үзэмчин хувцастай хүн байгаагүй, аймгийн музейд л үзэмчин эхнэр хүний хувцас байсан бол одоо наадмаараа үзэмчин дээл хувцсаа хоёр гурван зуугаараа өмсөнө. Буцаж сэргэж байна. Хуучин үзэмчин хүмүүсийг бага ястан, бараг хятад гэж зарим нь хэлдэг

байлаа. Одоо нийгэм чөлөөтэй сайхан болжээ. БНХАУ-д байгаа үзэмчин төрөл садантайгаа уулздаг болсон” хэмээн хуучилж байлаа.

Мөн Дорнод аймгийн Хэрлэн сум буюу Чойбалсан хотод ажиллаж байгаа “Үзэмчин брэнд”-ийн үүсгэн байгуулагч Т.Мөнхцэцэг өөрийн брэндийн талаар болон үзэмчин хэл соёлын тухайд “Үзэмчин аялгаар өдөр тутам ярихгүй, үзэмчин хэл аялгуу маш их алдагдаж байна. Манай үзэмчин брэнд бол өв соёлыг түгээх зорилготой. Дорнод аймгийнхаа хэмжээнд таниулж байна. Хүмүүс орж ирээд манай бүтээгдэхүүнийг Өвөр Монголоос авч ирсэн юм уу гэж их асуудаг. Тэгэхэд нь бид үзэмчин гэдэг чинь өвөр монгол биш, цэвэр монгол угсаатан шүү дээ хэмээн тайлбарладаг. Хүндэтгэлийн идээ болох ‘Жарьяасан бадаа’ (царцаасан будаа), өдөр тутмын ‘Дугтардаг цай’ гэх тэргүүтэн долоон төрлийн эко цай үйлдвэрлэн дотоод гадаадад түгээж байна” хэмээн өгүүлсэн нь үзэмчин соёлын тухайд сонин содон зүйл байлаа. Ийнхүү “Үзэмчин брэнд” нь үзэмчин өв соёлыг таниулах, үзэмчин идээ ундааны соёлыг түгээн дэлгэрүүлэх талаар маш их ажил хийж байна.

Эдүгээ Дорнод аймгийн үзэмчин түмний дунд өөрийн соёл түүх, бахархлын хувьд сэргэн өндийж байгааг хөндлөнгөөс ажиглахад баярлан бахархмаар санагдаж байгаа ч хэл аялгын хувьд ихэд халхжин өөрчлөгдсөн нь бодит зүйл болжээ. Энэ тухайд судлаач Урадын Булаг “Монгол үндэстний биологи, соёлын гол цөм нь одоо Монгол дахь зонхилох үндэстэн буюу халхууд болсон нь илт. Хүн амын дийлэнх нь халхууд тул ‘Халх’ гэдэг нь ‘Монгол’ гэдэгтэй нэг утгатай байна. Халх бол ‘Жинхэнэ монгол’ гэж үзэх болсны нэг баталгаа бол 1940-өөд онд кирилл бичгийг нэвтрүүлэхдээ халх аялгад тааруулсан явдал юм. Тиймээс боловсрол эзэмшинэ гэдэг халхжих буюу монголжих явдал болж хувирчээ” (Булаг, 2016: 31) хэмээсэн байдаг нь бодуштай зүйл юм.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд 100 гаруй өрх үзэмчин угсаатан амьдарч байна. Өвөр Монголын Баруун үзэмчин хошуунаас нүүдэллэн ирсэн эдгээр үзэмчин ястны байдал Дорнод аймаг дахь үзэмчин ястны байдлаас нэлээд ялгаатай байна. Энэ нь нэг талаас тус сум нь Бичигт боомтоор БНХАУ-тай хиллэдэг нь байршлын шалтгаан буюу хятадтай ойр хэмээн хэлэгдэхээс болгоомжилсон, мөн урдаас ирсэн үзэмчин ард иргэдийг урд зүгийн гаралтай, бараг монгол угсаатан биш мэт үзэж ирсэн нийгэм сэтгэл зүйн дарамтаас шалтгаалсан байх магадлалтай.

Энэ тухайд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын үзэмчин ястан Чимэдийн Батгэрэл (59 настай) гуайгаас “Би энд ирээд нэг юм анзаарлаа. Дорнодоор явж байхад үзэмчин хүмүүс өөрсдийгөө үзэмчин гэдгээр илүү бахархах хандлагатай байхад Сүхбаатарын Эрдэнэцагаан суманд үзэмчин хүмүүс өөрсдийгөө нуух хандлага байна уу?” хэмээн асуухад “Манай суманд настнууд буюу жинхэнэ үзэмчин хүмүүс, хоёр талаасаа цэвэр үзэмчин хүмүүс ховор болчихлоо. Энд орж ирээд гарсан хүүхдүүд эцэг нь үзэмчин байхад эх нь халх, эсвэл буриад ч юм уу тийм байна. Эх нь үзэмчин хүн байхад эцэг нь халх эсвэл буриад хүн, ийм өөр болчихсон. Тэгэхээр цэвэр үзэмчин биш болоод явчхаж байгаа юм. Тэгэхээр тийм хүүхдүүд өөрсдийгөө үзэмчин гэж бодох ч үгүй болчихож байгаа юм. Биднийг бага байхад үзэмчин аялгаар ярингуут сургуульд хүүхдүүд хятад гээд шоолдог байлаа л даа. Тэгээд хятадууд нэг хөгийн сонин ярих юм гээд шоолно. Тэгэнгүүт сүүлдээ шоолуулахгүйн тулд халх аялгуунд суралцаад үзэмчин аялгаа бүр сольчихсон. Одоо бол тэгж гадуурхах зүйл байхгүй, учир нь үзэмчин халхаа ч бараг ялгахгааргүй болчихжээ. Бид нар бол өөрсдөө сайн мэднэ, энэний эх нь үзэмчин, эцэг нь халх хүн гэж мэднэ. Харин бид нараас хойших үе үүнийг нэг их анзаарахгүй учраас сайн мэдэх хүмүүс ховор болж байна. Ер нь цэвэр үзэмчин бид нарын үеэр бараг шувтрах гээд байна. Үзэмчин аялгаараа өдөр тутам ярихаа больжээ. Бага байх үед үзэмчин аялгаараа бүх юмаа хэлдэг байсан бол том болсноос хойш үзэмчин аялгуу маань маш их алдагдсан л даа. Үүнд хамт амьдарч байгаа өөр ястны хэл яриа нөлөөлсөн гэж би боддог. Үзэмчний ёс заншил ч манайханд нэлээн алдагдсан даа, нуль халх ёс заншлаар л явцгаагаад байгаа” хэмээн энэ нутгийн үзэмчин ёс заншил, хэл аялгууны алдагдсан байдлын талаар тодорхой өгүүлсэн юм.

Энэ талаар Урадын Булаг “Халхыг онцлон үзсэнээр бусад монголчууд шахагдан гадуурхагдаж, халх аялгаар ярьж суралцах зэргээр соёлын өвөрмөц онцлогоо гээн халх соёлд уусахад хүрч байсан байна” (Булаг, 2016: 56) гээд тэр үеийн халх төвт үзлийн тухайд “...халхууд

өөрсдийгөө бусад монголчуудтай харьцуулан, тусгаар тогтносон Монгол дахь ‘гал голомт сахигч үндэстэн’ гэж үздэг тэдний бахархал болох тухай өмнө өгүүлсэн. Тэдний энэ үзлийг монгол ижилслийг нэг бүлэг дээр суурилан тогтоож, бусад монголчуудыг түүнд уусгах зорилготой социализмын үеийн бодлого баталгаажуулж өгсөн юм” гэсэн байдаг. (Булаг, 2016: 124) Ийнхүү үзэмчин аялгууны хэрэглээний өнөөгийн байдлын тухайд үзэмчин угсаатан гэж байхаас үзэмчин аялгаар ярьдаг хүмүүс бараг байхгүй болж халх аялгуунд уусжээ гэж дүгнэхэд болмоор байна.

5. Хэрэглээний статистик судалгаа

Дорнод аймгийн Хэрлэн, Сэргэлэн, Баянтүмэн, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 170 орчим үзэмчин хүмүүстэй уулзаж, 15-24, 25-40, 40-50, 50-аас дээш насны гэсэн 4 ангиллаар үзэмчин аялгуу, соёл, ёс заншлын өнөөгийн байдал, хэрэглээний талаар өөрсдийн нь үнэлэмжээр асуулга, судалгаа авав. Үүнд:

5.1. Өсвөр нас

Хүснэгт 1. Үзэмчин аялгуу, ёс заншлын өнөөгийн байдлын талаарх асуулга судалгаа (Өсвөр нас)

15-18 нас	Нийт	маш бага		Бага		Дунд		Их		маш их	
	100%	хүн	%	хүн	%	Хүн	%	хүн	%	хүн	%
Үзэмчин аялгуугаар хэлэлцэхэд ямар нэгэн асуудал тулгардаг уу?	44	8	18.2	7	15.9	10	22.7	10	22.7	9	20.5
Үзэмчин аялгуугаар ярихаас ичдэг үү?	44	11	25.0	11	25.0	8	18.2	7	15.9	7	15.9
Найз нөхөд шоолдог уу?	44	15	34.1	10	22.7	9	20.5	3	6.8	7	15.9
Гэртээ үзэмчин аялгуугаар ярьдаг уу?	44	16	36.4	11	25.0	8	18.2	2	4.5	7	15.9
Найз нөхдийн хүрээнд үзэмчин аялгуугаар ярьдаг уу?	44	15	34.1	14	31.8	8	18.2	7	15.9	-	
Сургууль дээрээ үзэмчин аялгуугаар ярьдаг уу?	44	20	45.5	14	31.8	10	22.7	-		-	
Анги танхимдаа үзэмчин аялгуугаар ярьдаг уу?	44	20	45.5	12	27.3	8	18.2	4	9.1	-	
Үзэмчин аялгуугаар ярихыг багш зөвшөөрдөг үү?	44	8	18.2	9	20.5	8	18.2	7	15.9	12	27.3
Өөрийн гарал угсааг хэр мэддэг вэ?	44	9	20.5	10	22.7	18	40.9	6	13.6	1	2.3

5.2. Залуу нас

Хүснэгт 2. Үзэмчин аялгуу, ёс заншлын өнөөгийн байдлын талаарх асуулга судалгаа (Залуу нас)

19-35 нас	Нийт	маш бага		Бага		Дунд		Их		маш их	
	100%	хүн	%	хүн	%	Хүн	%	хүн	%	хүн	%
Гэртээ үзэмчнээр ярьдаг уу?	43	26	60.5	10	23.3	4	9.3	3	7.0	-	
Найз нөхдийн хүрээнд үзэмчнээр ярьдаг уу?	43	25	58.1	13	30.2	3	7.0	1	2.3	1	2.3
Үзэмчин ёс заншлаа сайн мэддэг үү?	43	2	4.7	15	34.9	13	30.2	4	9.3	9	20.9
Үзэмчний түүх соёлын талаар мэддэг үү?	43		0.0	2	4.7	24	55.8	2	4.7	15	34.9
Үзэмчин аялгуу алдагдаж байна уу?	43	5	11.6	6	14.0	9	20.9	15	34.9	8	18.6
Үзэмчин аялгуу алдагдахад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэр нөлөөлж байна вэ?	43	3	7.0	4	9.3	6	14.0	12	27.9	18	41.9
Үзэмчин аялгуу алдагдахад зах зээл, эдийн засгийн харилцаа хэр нөлөөлж байна вэ?	43	1	2.3	10	23.3	2	4.7	26	60.5	4	9.3
Та өөрийн гарал угсааг хэр мэддэг вэ?	43	4	9.3	6		17	39.5	11	25.6	5	11.6

5.3. Дунд нас

Хүснэгт 3. Үзэмчин аялгуу, ёс заншлын өнөөгийн байдлын талаарх асуулга судалгаа (Дунд нас)

35-50 нас	Нийт	маш бага		Бага		Дунд		Их		маш их	
	100%	хүн	%	хүн	%	Хүн	%	хүн	%	хүн	%
Үзэмчин аялгуу алдагдаж байна уу?	40	1	2.5	2	5	3	7.5	8	20	26	65
Үзэмчин аялгуу алдагдахад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл	40	8	20	2	5	11	27.5	10	25	9	22.5

нөлөөлж байна уу?											
Үзэмчин аялгуу алдагдахад зах зээл, эдийн засгийн харилцаа нөлөөлж байна уу?	40	9	22.5	1	2.5	11	27.5	10	25	9	22.5
Үзэмчний ард түмний ёс заншил алдагдаж байна уу?	40	8	20	2	5	9	22.5	12	30	9	22.5
Үзэмчний уламжлалт ахуй алдагдаж байна уу?	40	11	27.5	1	2.5	3	7.5	14	35	11	27.5
Та үзэмчин аялгуугаараа өдөр тутам ярьж байна уу?	40	30	75	7	17.5	3	7.5	-		-	
Үзэмчний соёлыг хамгаалах төр засгийн бодлого хэр байна вэ?	40	15	37.5	8	20	8	20	1	2.5	8	20
Та үзэмчний уламжлалт зан үйлийн талаар хэр мэдэх вэ?	40	6	15	8	20	20	50	-		6	15
Та үзэмчин ардын аман зохиол, язгуур урлагийн талаар хэр мэдэх вэ?	40	26	65	5	12.5	3	7.5	1	2.5	5	12.5
Та үзэмчний уламжлалт тоглоом наадгайг хэр мэдэх вэ?	40	16	40	12	30	5	12.5	3	7.5	4	10
Та үзэмчний амьдрал, эрхэлдэг аж ахуйн талаар хэр мэдэх вэ?	40	8	20	19	47.5	6	15	-		7	17.5
Та үзэмчний түүх соёлын талаар хэр мэдэх вэ?	40	8	20	17	42.5	12	30	1	2.5	2	5
Та өөрийн гарал угсааг хэр мэддэг вэ?	40	5	12.5	19	47.5	10	25	6	15	-	

5.4. Ахмад нас

Хүснэгт 4. Үзэмчин аялгуу, ёс заншлын өнөөгийн байдлын талаарх асуулга судалгаа (Ахмад нас)

50-аас дээш нас	Нийт	маш бага		Бага		Дунд		Их		маш их	
	100%	хүн	%	хүн	%	Хүн	%	хүн	%	хүн	%
Таны бага байх үеийнхээс үзэмчин аялгуу алдагдсан уу?	42	-		1	2.4	4	9.5	13	31.0	24	57.1
Үзэмчин аялгуу алдагдахад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нөлөөлж байна уу?	42	-		7	16.7	21	50.0	9	21.4	5	11.9
Үзэмчин аялгуу алдагдахад зах зээл, эдийн засгийн харилцаа нөлөөлж байна уу?	42	5	11.90	15	35.7	8	19.0	14	33.3	-	
Үзэмчний ард түмний ёс заншил алдагдаж байна уу?	42	2	4.76	19	45.2	8	19.0	3	7.1	10	23.8
Үзэмчин уламжлалт ахуй алдагдаж байна уу?	42	-		6	14.3	13	31.0	21	50.0	2	4.8
Та үзэмчин аялгуугаараа өдөр тутам ярьж байна уу?	42	21	50	14	33.3	7	16.7	-		-	
Үзэмчин түмний соёлыг хамгаалах төр засгийн бодлого хэр байна вэ?	42	16	38.10	13	31.0	7	16.7	6	14.3	-	
Та үзэмчний уламжлалт зан үйлийн талаар хэр мэддэг вэ?	42	2	4.76	10	23.8	16	38.1	8	19.0	6	14.3
Та үзэмчин ардын аман зохиол, язгуур урлагийн талаар хэр мэддэг вэ?	42	12	28.57	7	16.7	16	38.1	2	4.8	5	11.9
Та үзэмчний уламжлалт тоглоом наадгайг хэр мэддэг вэ?	42	19	45.24	3	7.1	13	31.0	4	9.5	3	7.1
Та үзэмчний	42	2	4.76	1	2.4	14	33.3	5	11.9	20	47.6

амьдрал, аж ахуйн талаар хэр мэдэх вэ?											
Та үзэмчний түүх соёлын талаар хэр мэддэг вэ?	42	3	7.14	3	7.1	16	38.1	7	16.7	13	31.0
Та өөрийн гарал угсааг хэр мэддэг вэ?	42	-		-		28	66.7	9	21.4	5	11.9

6. Судалгааны үр дүн

Судалгаанд дараах насны дараах тооны (оролцооны хувьд тэгш) үзэмчин хүмүүс хамрагдав. Үүнд:

Хүснэгт 5. Үзэмчин аялгуу, ёс заншлын өнөөгийн байдлын талаарх асуулга судалгаа (Нийт)

Насны ангилал	Нийт
15-18 нас	44
19-35 нас	43
35-50 нас	40
50 наснаас дээш	42
Нийт	169

Хариултыг нэгтгэн үзвэл 15-18 настай хүүхдүүдийн 13.6% нь үзэмчнээр ярьдаг (их, маш их), ямар нэг асуудал тулгардаггүй (маш бага, бага) гэж хариулсан, 18-35 настай залуучуудын 11.6% нь үзэмчнээр ярьдаг, ёс заншлаа мэддэг (их, маш их), үзэмчин салбар аман аялгуу алдагдаагүй байна (маш бага, бага) гэж хариулсан, 35-50 настай хүмүүсийн 8.6% нь үзэмчнээр ярьдаг, түүх, ёс заншил, аман зохиолоо мэддэг (их, маш их), үзэмчин салбар аман аялгуу, ёс заншил алдагдаагүй байна (маш бага, бага) гэж хариулсан, 50-аас дээш настай ахмадуудын 13.5% нь үзэмчнээр ярьдаг, түүх, ёс заншил, аман зохиолоо мэддэг (их, маш их), үзэмчин салбар аман аялгуу, ёс заншил алдагдаагүй байна (маш бага, бага) гэж хариулсан байна. Графикаар үзүүлбэл:




График 1. Үзэмчин аялгуу, ёс заншилн өнөөгийн байдлын талаарх асуулга судалгааны дүн

Үүнээс, үзэмчний хэл аялгуу, түүх, ёс заншил, ахуй соёл хадгалагдаж байна хэмээсэн эерэг үнэлгээг дунджилж үзвэл үзэмчин хүмүүсийн өөрсдийн нь үнэлснээр дунджаар **11.8** байгаа юм. Дотор нь нарийвчлан харвал залуу үе, ялангуяа дунд үеийнхний эзлэх эерэг үнэлгээний хувь бага байгаа нь дээр дурдсан 1990-ээд оноос өмнөх нийгмийн хандлагын үр дүн, нөгөө талаар сурч боловсрох, ажиллах зэрэг янз бүрийн зорилгоор хот суурин газарт удаан хугацаагаар суух, кирилл бичгийн хэлтэй өдөр тутам харьцаж ажиллаж байгаа зэрэг шалтгаантай байж болох юм. Харин ахмад үеийнхний эерэг хариултын эзлэх хувь харьцангуй арай өндөр байгаа нь тэдний ухамсар, амьдралын ухаан, мөн өсвөр үеийнхний эерэг хариултын эзлэх хувь нь өвөө, эмээгийн гэрийн хүмүүжил, басхүү сүүлийн үеийн нийгэм дэх үзэл ухамсрын сэргэлтийн нөлөө байж болох талтай. Гэхдээ энэ бол судалгаанд хамрагдсан үзэмчин хүмүүсийн өөрсдийн дүгнэлт бөгөөд магадгүй судалгааны өөр аргаар, хөндлөнгийн судалгаа хийж үзвэл өөр үр дүн гарч болохыг үгүйсгэхгүй. Ерөнхийдөө үзэмчин түүх, ёс заншлаа мэдэх хүмүүс улам бүр нэмэгдэж байгаа бол хэл аялгууны хувьд өөрийн өвөрмөц онцлогоо гээсээр байгаа нь судалгаанаас тодорхой харагдаж байна.

7. Дүгнэлт

Сүүлийн үед залуучууд монголоо алдах биш харин ч олох гэж дээлээ өмсөж, хөөргөө барьж, ёс заншлаа дагах гэж хичээж, үндэсний юм бүхэн сэргэж, өргөжин дэлгэрч байна. Үүний дунд үзэмчин угсаатны ёс заншил ч нэлээд сэргэж байгаа хандлага тэдний дунд биеэр явж, ажиглан судлахад харагдаж байна. Ийнхүү үзэмчин түмний дунд өөрийн соёл түүх, бахархлын хувьд сэргэн өндийж байгааг хөндлөнгөөс ажиглахад баярлан бахархмаар санагдаж байна.

Гэвч хэл аялгын хувьд ихэд халхжин өөрчлөгдсөн нь бодит зүйл болжээ. Үзэмчин угсаатны өнөөгийн байдлын тухай дүгнэж хэлбэл, үзэмчин угсаатан, түүх, соёл гэж байхаас үзэмчин аялгуу гэж бараг байхгүй болж халх аялгуунд уусжээ гэж дүгнэж болохоор байна. Иймээс ч бид төслийн үр дүнд хэвлүүлсэн бүтээлдээ Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх үзэмчин аман аялгуу нь зүүн халх аман аялгууны “халхажсан өвөр монгол (үзэмчин, харчин) салбар аман аялгуу” (Батзаяа нар, 2022, 36) гэж үзсэн юм.

8. Талархал

“Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” сэдэвт суурь судалгааны төслийн хамт олондоо талархал дэвшүүлье. Мөн 2024 оны 5-р сард үзэмчин хэл аялгууны судалгааны ажлаар Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн, Сэргэлэн, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумдад ажиллахад тусалж дэмжсэн төр ба хувийн хэвшлийнхэн, статистик судалгаанд хамрагдсан үзэмчин иргэд, хэл соёл, ёс заншлынхаа талаар дэлгэрэнгүй сайхан яриа өгсөн нийт үзэмчин түмэндээ талархал илэрхийлье.

9. Хавсралт

Уулзаж ярилцлага хийсэн үзэмчин хүмүүс:

- Лэвгэрийн Түвдэнням, настай, 71 настай, эрэгтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум
- Буянтогтохын Тогоо, 35 настай, эрэгтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум
- Тавнайн Мөнхцэцэг, 41 настай, эмэгтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум
- Аюурзанын Отгончимэг, 34 настай, эмэгтэй, Дорнод аймгийн Сэргэлэн сум
- Нэхийтийн Гүррагчаа, 43 настай, эрэгтэй, Дорнод аймгийн Сэргэлэн сум
- Чандагын Жамсранжав, 85 настай, эрэгтэй, Дорнод аймгийн Баянтүмэн сум
- Дамбаажамцын Ууганбаяр, 71 настай, эмэгтэй, Дорнод аймгийн Баянтүмэн сум

- Жамсранжавын Батжаргал, 44 настай, эмэгтэй, Дорнод аймгийн Баянтүмэн сум
- Дамирангийн Мөнхөө, 80 настай, эрэгтэй, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум
- Ундрахын Уртнаст, 73 настай, эмэгтэй, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум
- Чимэдийн Батгэрэл, 59 настай, эрэгтэй, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум

Ном зүй

- Алимаа, А., Болормаа, Д., Боролзой, Д., Гэрэлмаа, Г., Мөнхбат, Ё., Очирцэнд, М., Пүрэвжав, Э., Сумьяа, Д., Ууганбаатар, Ж., Энхжаргал С. (2021). *Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн. 100 жил, 100 үйл явдал, 100 зураг, 100 эрдэмтэн*, Улаанбаатар: Соёмбо хэвлэлийн үйлдвэр. [Alimaa, A., Bolormaa, D., Borolzoi, D., Gerelmaa, G., Mönkhbat, Yo., Ochirtsend, M., Pürevjav, E., Sumiya, D., Uuganbaatar, J., Enkhjargal, S., *Shinjelekhi ukhaany akademiin khel zokhiolyn khüreeleen. 100 jil, 100 uil yavdal, 100 zurag, 100 erdemten* [Institute of language and literature of Mongolian academy of sciences. 100 years, 100 events, 100 photos, 100 scientists]. Ulaanbaatar: Soyombo publishing company. 2021.]
- Алимаа, А., Катгуу, Б. (2004). *Монгол аман зохиол, нутгийн аялгууны хөмрөгийн бүртгэл*, Улаанбаатар. [Alimaa, A., Katuu, B., *Mongol aman zokhiol, nutgiin ayalguuny khömrögiin бүртгел* [Mongolian folklore and local dialects collection register]. Ulaanbaatar. 2004]
- Батзаяа, Г. (2012). Монгол нутаг дахь үзэмчний салбар аман аялгуу. *Улаанбаатар дээд сургуулийн эрдэм шинжилгээний баг Буйр нуур, Дарьгангын нутгаар*, Улаанбаатар. [Batzaya, G. Mongol nutag dakhi üzemchinii salbar aman ayalguu. *Ulaanbaatar deed surguuliin erdem шинжилгээний баг buir nuur, darigangyn nutgaar* [The oral dialect of the uzemchin branch in Mongolia, a research team from Ulaanbaatar University in the Buir Lake and Dariganga regions]. Ulaanbaatar. 2012]
- Батзаяа, Г., Батдорж, Ц., Баярчимэг, Э. (2021). *Монгол хэл судлал. Нутгийн аялгуу. VI боть*, Улаанбаатар. [Batzaya, G., Batdorj, Ts., Bayarchimeg, E. *Mongol khel sudlal. Nutgiin ayalguu* [Mongolian linguistics. Local dialects. Volume VI]. Ulaanbaatar. 2021]
- Булаг, Э. (2016). *Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил*, Улаанбаатар. [Bulag, E. *Mongol dakhi ündesnii üzel ba erliizhil* [Nationalism and hybridization in Mongolia]. Ulaanbaatar. 2016]
- Лувсанданзан. (1990). *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршивай*. Улаанбаатар. [Luvsandanzan. *Ertnii khaadiin ündeslesen tür yosny zokhioliig товчлон khuraasan altan товч khemeekh orshibai* [The Altan товч, a concise collection of official writings based on ancient kings]. Ulaanbaatar. 1990]
- Наранцэцэг, Д. (2016). *Үзэмчний түүх соёлын ойлго*. Улаанбаатар. [Narantsetseg, D. *Üzemchnii түүхkh soyolyn oillogo* [Uzemchin's understanding of history and culture]. Ulaanbaatar. 2016]
- Пүрэвжав, Э. (2016). *Монгол хэл бичгийн судлал*. Улаанбаатар. [Pürevjav, E. *Mongol khel bichgiin sudlal* [Mongolian philology]. Ulaanbaatar. 2016]
- Пүрэвжав, Э. (2023). *Жодовжавын Төмөрцэрэн. Монгол хэл шинжлэлийн өгүүллүүд-1*: 416-424. [Pürevjav, E. *Jodovjavyn Tömörtseren. Mongolian linguistics articles-1*, 2023: 416-424.]
- Ринчен, Б. (2007). *Монгол бичгийн хэлний зүй*. Улаанбаатар. [Rinchen, B. *Mongol bichgiin khelnii зүй* [Mongolian written language study]. Ulaanbaatar. 2007]
- Төмөрцэрэн, Ж. ([1974] 2023). *Үзэмчин аман аялгууны харшуулсан түүхэн судлал. Монгол хэлний үзэмчин аялгууны судлал (эрхлэн хэвлүүлсэн Д.Боролзой, Г.Батзаяа). II боть*: 10-135. [Tömörtseren, J. Comparative and historical study of Uzemchin dialect. *A study of the Üzemchin dialect of the Mongolian language. Volume II*: 10-135.]
- Хонгорговь, Л. (2022). *Üjümčin-ü öbermiče kelče*. Kökeqota. [Khongorgovi, L. *Üzemchnii övörmöts khelts* [Uzemchin phrase]. Hohhot. 2022]
- Хөхбарс, Чимэг. (1997). *Üjümčin aman аялгуу*. Kökeqota. [Khökhbars, Chimeg. *Üzemchin aman аялгуу* [Uzemchin dialect]. Hohhot. 1997]